



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/04/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: Oyun-Erdenet@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
.....	5
Хоёр .АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
Гурав. Аудитын илрүүлэлт	8
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	11
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА

2025.03.25 № 23

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 98.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн тайлан дахь 9.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй;
- Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус онд эвлэрлийн гэрээний хугацаа дууссан 2 иргэний 28.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй;
- Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 14.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 741.8.-д, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.-д, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д, заалтуудтай нийцэхгүй байна.

4825020285

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.5 дахин их, зардлыг жишиг хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй авлага болон хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүг барагдуулах арга хэмжээ аваагүй нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, сумын бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2 төсвийн байгууллагын 2024 онд 4 албан хаагч 32.2 сая төгрөгийн дэмжлэг авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 15.0 сая төгрөгийн хөрөнгө, 12.0 сая төгрөгийн өр төлбөрийг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл 2023 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангаас 2.5 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл, улсын төсвийн байгууллагын төвлөрүүлсэн дүнг устгал хийсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 110 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 67.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хугацаа хоцруулж ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний

баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

Хоёр .АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,212,986.0	2,973,079.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	871,839.1	2,237,529.4
33	АВЛАГА	226,326.0	518,668.9
35	БАРАА МАТЕРИАЛ	114,821.0	180,980.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	35,900.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,821,572.5	5,783,247.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,821,572.5	5,783,247.8
39200	Биет хөрөнгө	5,745,583.1	5,710,604.5
39300	Биет бус хөрөнгө	75,989.4	72,643.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,034,558.6	8,756,327.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,930,280.1	2,342,109.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,774.3	82,119.2
41300	Өглөг	42,774.3	82,119.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,887,505.8	2,259,990.0
42200	Урт хугацаат зээл	1,887,505.8	2,259,990.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,104,278.5	6,414,217.7
51	Засгийн газрын хувь оролцоо	5,104,278.5	6,414,217.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	488,428.3	488,428.3
51200	Хуримтлагдсан үр дүн	3,825,666.5	5,135,614.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	790,183.7	790,175.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,034,558.6	8,756,327.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,609,605.8	3,877,547.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	775,428.8	1,530,727.8
110	Орлогын албан татвар	532,365.6	1,235,420.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	532,365.6	1,235,420.6
113	Хөрөнгийн албан татвар	121,831.4	144,112.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	121,231.8	151,194.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	437,534.9	717,783.0
120	Нийтлэг татварын бус орлого	437,534.9	717,783.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,396,642.2	1,629,036.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,223,513.3	2,067,581.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,223,513.3	2,048,581.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,246,672.3	1,986,574.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,550.5	611,650.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,605.4	73,418.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,246.4	393,573.2
2104	Хангамж, бараа материалын зардал	26,102.7	71,938.6
2105	Норматив зардал	0.0	6,986.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,452.6	24,487.2
2107	Томилолт, зочны зардал	14,346.0	23,062.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246,531.0	32,305.7

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	451,837.6	749,152.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	976,841.0	62,007.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	19,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	386,092.5	1,809,965.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	124,792.4	468,018.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	261,300.1	1,341,946.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,843,353.9	4,843,353.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-375.5	-375.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,842,978.4	4,842,978.4
9	Тайлант үеийн үр дүн	261,300.1	261,300.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,104,278.5	5,104,278.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,104,278.5	5,104,278.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-32,007.7	-32,007.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,072,270.8	5,072,270.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	8.7	8.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-8.7	-8.7
19	Тайлант үеийн үр дүн	1,341,946.9	1,341,946.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,414,217.7	6,414,217.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,378,269.3	3,299,746.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	775,428.8	1,530,727.8
110	Орлогын албан татвар	532,365.6	1,235,420.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	532,365.6	1,235,420.6
113	Хөрөнгийн албан татвар	121,831.4	144,112.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	121,231.8	151,194.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,308.2	22,525.1
1181	Газрын төлбөр	109,923.6	128,669.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,624.6	142,744.4
120	Нийтлэг татварын бус орлого	153,624.6	142,744.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,215.8	1,626,274.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	887,413.0	1,466,890.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,413.0	1,466,890.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,970.8	1,404,883.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,219.5	613,300.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,899.9	73,418.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,459.4	401,413.7
2104	Хангамж, бараа материалын зардал	28,452.2	36,755.0
2105	Норматив зардал	650.0	1,905.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,138.5	29,859.2
2107	Томилолт, зочны зардал	14,346.0	23,062.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246,528.0	32,308.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,277.3	192,860.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,442.1	62,007.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	490,856.3	1,832,856.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	178,942.9	467,166.2

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	178,942.9	467,166.2
2200	Догоод эх үүсвэрээр	178,942.9	467,166.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-178,942.9	-467,166.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	311,913.4	1,365,690.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	559,925.7	871,839.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	871,839.1	2,237,529.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,012,744.6	1,868,568.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,628,056.4	1,416,832.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,588,907.4	1,377,958.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,419.9	613,300.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,978.2	73,418.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	398,056.8	396,918.6
2104	Хангамж, бараа материалын зардал	32,163.7	32,082.8
2105	Нормативт зардал	1,790.0	1,790.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,507.0	43,554.5
2107	Томилолт, зочны зардал	23,200.0	23,062.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,487.7	3,290.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	334,304.1	190,540.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,149.0	38,874.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,149.0	38,874.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,253,606.5	451,736.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	131,081.7	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,012,744.6	3,168,640.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,568,822.9	1,506,069.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,658,211.4	1,555,321.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	785,710.3	107,249.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	684,518.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,984,590.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,107.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,107.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,974.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,495.2
2104	Хангамж, бараа материалын зардал	4,672.2
2105	Норматив зардал	115.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	674.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,018.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,132.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,132.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,107.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,107.9

Гурав. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Гурвансайхан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар алдаа, зөрчил илрээгүй, харин мал хамгаалах болон байгаль хамгаалах сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 16,010.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 868.0 мянган төгрөгийн 1 алдаа залруулж, 15,142.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 868.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Байгаль хамгаалах сангийн дутсан өвсний авлагыг бүртгэхдээ үр дүнгийн тайланд орлогоор тайлагнасан;

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 15,142.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлсэн.

3.1. Албан шаардлага

3.1.1 Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 318.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх/, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, 16.5.2-д /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/ заасныг;

3.1.2 Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 14,823.5 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагд	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1				1		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5			1		

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 319,214.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,462.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 760.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 316,992.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлагыг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 99.5 хувийг залруулагдаагүй, 0.5 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 164,616.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 93,774.4 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин их байна.

Иймд Гурвансайхан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	594.0			1	594.0	1	594.0				
БХС	1	868.0			1	868.0	1	868.0				
Дүн	2	1,462.0			2	1,462.0		1,462.0			-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	5	113,782.5			5	113,782.5						
ХХС	1	28,232.1			1	28,232.1						
ОНХС	1	760.0	1	760.0		0.0						
БХС	1	14,823.5			1	14,823.5						
МХС	1	318.6			1	318.6						
Нийт дүн	9	157,916.6	1	760.00	8	157,156.6				-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЗДТГ	1	5,454.8			1	5,454.8						

Дундговь аймгийн Гурвансайхан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ИТХ	1	8,585.0			1	8,585.0					
ОНХС	2	145,795.9			2	145,795.9					
	4	159,835.7			4	159,835.7					

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1			1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	4		4					
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	7	2	5			2		